



Зөгийн аж ахуйн бизнес менежментийн гарын авлага (ver.2) тун удахгүй бэлэн болно !

BeeDep төслийн үйл ажиллагааны түшиц газар нь Дархан-Уул аймаг бөгөөд энд хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд тулгуурлан зөгийн аж ахуйд зориулсан нэгдсэн гарын авлага бий болгохоор ажиллаж байна. Өнгөрсөн жил энэхүү гарын авлагын нэг хэсэг болох зөгийн арчилгаа маллагаа болон зөгийн балны чанарын мөн бизнес менежментийн гарын авлагын урьдчилсан хувилбарыг (Ver. 1) бэлтгэсэн.



Өнөөг хүртэлх үйл ажиллагааны хүрээнд нэгтгэсэн санал, хамтын ажиллагаанд тулгуурлан зөгийн аж ахуйн бизнес менежментийн гарын авлагын шинэчилсэн хувилбарыг (Ver.2) бэлтгэж байна. Шинэчилсэн хувилбар нь тухайн аж ахуйн бүтээгдэхүүний давуу тал, зорилтот хэрэглэгчдийн хандлага, үйлдвэрлэлийн өртгийг тооцох арга, брэнд бүтээгдэхүүн бий болгох гэх мэт практик мэдлэгийг олж авахад туслах юм. Шинэчилсэн хувилбарыг (Ver. 2) 4 дүгээр сарын сүүлийн хагаст бэлэн болгохоор төлөвлөж байна. Бид өнгөрсөн 3 дугаар сард бизнес менежментийн гарын авлагад багтсан сэдвүүдээр онлайн хичээл (Дугаар: 16 - 19) бэлтгэн төслийн фэйсбүүк хуудсанд байршуулсан билээ. Та бүхэн үзээрэй.

Бусад талуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж байна.

Гуравдугаар сарын 3-ны өдөр НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас (FAO) Монголд хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх” төсөл (LCP), ЖАЙКА-гийн “ХАА-н салбарын нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах” төсөл (JICA-MONMAP)-тэй гурван талын мэдээлэл солилцох уулзалт хийв. LCP төслийн хувьд малын эмч нарт зориулсан үргэлжилсэн сургалтын хөтөлбөрийг боловсруулж буй бөгөөд зөгийн эрүүл мэндийн чиглэлээр малын эмчид зориулсан хөтөлбөр боловсруулахад BeeDep төсөл хамтран ажиллав. Мөн JICA-MONMAP төсөл нь BeeDep төслөөс бий болсон үр дүнг ашиглан зөгийн балны чиглэлээр хэрэгжих туршилтын төслийн хүрээнд малын эмч, хүнсний аюулгүй байдал хариуцсан байцаагч нарт сургалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

Дөрөвдүгээр сарын 6-ны өдөр Булган аймаг дахь МСҮТ-тэй онлайн уулзалт хийлээ. Булган аймгийн хэмжээнд “Булган зөгий” хөтөлбөрийг 2019 оноос хэрэгжүүлж байгаа ба хөтөлбөрийн хүрээнд тус сургалт үйлдвэрлэлийн төв нь зөгийн аж ахуй эрхлэгч бэлтгэх анги энэ хавраас шинээр нээсэн байна. BeeDep төслөөс хамтран ажиллах боломж, сургалтын хөтөлбөрийн талаар мэдээлэл өглөө.

BeeDep төсөл нь холбогдох байгууллагуудтай тогтмол мэдээлэл солилцож хамтын ажиллагааг хэрэгжүүлэх болно.



ТӨСЛИЙН БАГИЙН ТАНИЛЦУУЛГА ②



Дэд менежер Майко Мори

Сүүлийн нэг жилийн хугацаанд Монголд очиж чадахгүй байгаа нь харамсалтай боловч онлайн семинарт холбоотойгоор зөгийчдийн маш олон сэтгэгдлийг хүлээн авч байдаг. Цаашид ч бас та бүхний санал сэтгэгдлийг хүлээж байх болно.



Төслийн хөтөлбөрийн ажилтан Д.Ууганбаяр

BeeDep төсөл манай улсад хэрэгжиж байгаа нь тун азтай явдал бөгөөд энэ боломжийг үр дүнтэй ашиглах нь зөгийчид болон холбогдох мэргэжилтнүүдийн санал санаачилгаас ихээхэн хамаарна. Амжилттай хамтран ажиллаж буй зөгийчид мөн байгууллагуудад талархал илэрхийлье.

Төслийн Facebook :

www.facebook.com/BeeDep-MONGOL-2-107843977265085/?modal=admin_todo_tour

Онлайн семинарыг хүргэж байна !

